



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 169

Мандалговь

**Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**


1. Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст өөрийн хөрөнгөнөөс 2'620'000 /хоёр сая зургаан зуун хорин мянга/ төгрөгийн эд хөрөнгө худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Ч.Ганбаярт даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 05 сарын  
23 өдрийн 169р тогтоолын хавсралт



Худалдан авах хөрөнгө

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Ханын стенк	Ш	1	730 000	730 000
2	Бичгийн ширээ	Ш	1	650 000	650 000
3	Хурлын ширээ	Ш	1	460 000	460 000
4	Сандал	Ш	8	60 000	480 000
5	Зөөлөвтэй сандал	Ш	1	300 000	300 000
	Бүгд дүн				2 620 000